



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГА
Ц.ГАНСҮХ ТАНАА

МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-2460,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2014.08.08 № 03/6640
танай _____-ны № _____-т

Авлигын эсрэг хууль тогтоомжийг
хэрэгжүүлэх тухай

Авлигатай тэмцэх газрын ажлын хэсэг тус аймгийн авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалтай танилцах явцад албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны акт гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээртэй холбогдох үйл ажиллагаанд оролцох зөрчлүүд нийтлэг байна.

Тухайлбал, тус сумын Засаг даргын Тамгын газрын дарга Г.Нэргүй нь 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/86 дугаар тушаалаар төрийн албан хаагчийн нийгмийн асуудал болон 2013, 2014 онуудын өвөлжилтийн бэлтгэлийг хангах хүрээнд түлшний хөнгөлөлтөд зориулсан зардлаас 81 000 төгрөгийг өөртөө олгохоор шийдвэрлэсэн нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д заасныг зөрчсөн байх бөгөөд мөн хуулийн 8.6-д заасны дагуу ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсвэл тухайн албан тушаалтан уг нөхцөл байдалд бичгээр тайлбар хийж, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх үүргээ хэрэгжүүлээгүй байна

Иймд албан тушаалтныг ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хүрээнд хуульд заасан нийтлэг үүргүүдийн хэрэгжилтийг хангаж, авлигын эсрэг хууль хууль тогтоомжийг сурталчлан таниулах ажлыг эрчимжүүлэх талаар зохих арга хэмжээг авч хэрэгжүүлнэ үү.

ТАМГЫН ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР



Б.ДОНЬЖЧИМБУУ

C:\DOCUMENTS\ALBANBICHIIG\4

011520